

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

### Нэг. Зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Улсын Их Хулын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт болон үр дүнг тодорхойлж, хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай дүгнэлт, зөвлөмж боловсруулах, тайланг нэгтгэн хэлэлцүүлэх, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

### Хоёр. Арга зүй

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 дахь заалтыг баримтлан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

### Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан 27 арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахаас 22 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон чиг үүрэгт хамааралгүй нийт 5 арга хэмжээг үнэлгээнээс хасаж тооцлоо.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр үр дүнтэй буюу “100.0” хувийн хэрэгжилттэй 20 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай буюу “30.0” хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээ байгаа бөгөөд дунджаар 93.6 хувийн хэрэгжилттэй байна.

### Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний үнэлгээ

ДД	Зорилт	Нийт арга хэмжээ	Үнэлсэн арга хэмжээ	Дундаж үнэлгээ
1	Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх	6	6	100.0
2	Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх	5	4	100.0
3	Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх	5	2	100.0
4	Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх	2	2	30.0
5	Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх	4	3	100.0
6	Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих	3	3	100.0

7	Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх	2	2	100.0
	Нийт	27	22	93.6

**Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

- Чиг үүрэгт хамааралгүй арга хэмжээг хяналтаас хасуулах;
- Эрчимжүүлэх шаардлагатай буюу “30.0” хувийн хэрэгжилттэй 2 арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

\*\*\*оОо\*\*\*

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг,  
хөгжлийн сайдын 2023 оны ... дүгээр сарын ...-  
ны өдрийн ..... тоот албан бичгийн хавсралт

**Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилт**

ДД	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хэрэгжилт (Үр дүн)	Үнэлгээ
Нэг.	<b>Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх</b>			
1	4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилгох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилгодохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 сарын 16-ны өдрийн 598 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Мөн Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 сарын 16-ны өдрийн 599 дүгээр тогтоолоор Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг тус тус томилсноор үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан Шалгалтын комисс Төрийн албаны зөвлөлийн шалгалтын байранд 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр тусгай шалгалтыг зохион байгуулж, хамгийн өндөр оноо авч шалгалтад тэнцсэн 18 иргэнийг салбар зөвлөлийн тогтоолоор нэр дэвшүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянуулан төрийн жинхэнэ албан тушаалд томилсон. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд заасны дагуу төрийн захиргааны албан тушаалд томилгодохоор нэр дэвшсэн этгээдээс Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг гаргуулан ажиглаж байна. Тус яамнаас 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 140 албан хаагчийн мэдүүлэг (ХАСУМ) хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Эдийн засаг, хөгжлийн яамнаас нийтийн албанд томилгодохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг яамны <a href="https://med.gov.mn/">https://med.gov.mn/</a> цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагаа хэсгийн ХАСУМ-2022 нэрээр байршуулж олон нийтэд ил тод нээлттэй болгосон.	100.0
2		5. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн	- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам загвар батлах" тухай 17 дугаар тогтоолын 2.1.1, 2.1.4, 2.1.5, 2.1.6-д заасан нөөцийн бүртгэл хөдөлгөөнийг харьяалах салбар зөвлөл бүртгэнэ. Төрийн жинхэнэ албаны нөөцийн бүртгэл, хөдөлгөөнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдээлэх үүргийн хүрээнд төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа албан тушаалтны мэдээлэл, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн төрийн	100.0

		бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	албан хаагчийн өөрчлөлтийн бүртгэлийг хүний нөөцийн системд тухай бүр оруулан Төрийн албаны зөвлөлийг мэдээлжээр хангаж ажилласан.	
4.1.1.2.	Нийтийн албанд томилогдох албан тушаалтныг ёс зүй, мэдлэг, туршлага, ур чадварын шапгуурыг олон улсын жишигт шинэчлэх, туршаалтныг боловсролд мөрийт баримтлан дэвшүүлэх	1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шапгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	Яамны удирдах 18 албан тушаалтан, гүйцэтгэх 60 албан хаагч буюу нийт 78 төрийн захиргааны албан тушаалд хамаарах албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах зөвшөөрөл авах хүсэлтийг 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 03/510 тоот албан бичгээр (874 хуудас) Төрийн албаны зөвлөлд хургуулсан. Улмаар Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 471, 472, 473 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрлийг авч, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар баталсан. Эдийн засаг, хөгжлийн яамны сул орон тооны тусгай шалгалтын сонгон шалгаруулалтыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын тавигдах шаардлага болон хуульд заасан шаардлагад хангасан иргэдийг тусгай шалгалтад бүртгэн журмын дагуу хамгийн өндөр оноо авсан иргэдийг Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлж 18 иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд томилж сул орон тоог нөхөж ажилласан.	100.0
4.1.1.9.	Байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, солилцох боломжийг сайжруулах	1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	Төрийн байгууллагуудын дундын үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем болох <a href="https://erp.e-mongolia.mn/">https://erp.e-mongolia.mn/</a> -ыг яамны албан хэрэг хөтлөлтөд нэвтрүүлж, төрийн байгууллага хоорондын албан бичиг солилцооны дундын систем <a href="https://dosx.gov.mn">dosx.gov.mn</a> ашиглан байгууллага хооронд албан бичиг солилцож байна. Уг систем нь нийтийн түлхүүр үг /e-token/ ашиглан нэвтрэх, баталгаажуулах дэд бүтэц хангагдсан.	100.0
5		2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах	Эдийн засаг, хөгжлийн яам төрийн мэдээлэл солилцооны ХУР системд холбогдож, УБЕГ, ТЕГ, НДЭГ, ГИХИ-тай хөрөнгө оруулагчтай холбоотой мэдээллийг солилцон, хөрөнгө оруулагчийн нэгдсэн сан бүрдүүлж /e-invest.mn/, нэг цонхны үйлчилгээг цахимгаар явуулж байна.	100.0
6	4.1.1.10. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, туршаалтныг давтан	3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.	Авлигын эсрэг сургалтын саналыг 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэст хургуулсан. Авлигатай тэмцэх газрын авлигын эсрэг үйл ажиллагааны сургалтад 2022 онд удирдах албан тушаалтанд зориулсан-1, хуулийн мэргэжилтэнд зориулсан-1, эрх бүхий албан	100.0

сургах боломжийг бүрдүүлэх		<p>Түшаалтанд зориулсан-1, шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтад-15 албан хаагч хамрагдсан. Мөн хуулийн мэргэжилтэн, эрх бүхий албан түшаалтнуудад зориулсан Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг болон авлигатай тэмцэх чиглэлээр 2022 оны 9 дүгээр сард зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Мэдүүлэг гаргагчдын 2022 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргуулах бэлтгэл ажлын хүрээнд улсын хэмжээнд ажиллаж байгаа мэдүүлэг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан түшаалтнуудад зориулсан цахим сургалтад 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр яамны албан хаагч болон яамны харьяа Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсийн албан хаагчдыг хамруулсан.</p>
----------------------------	--	--

**Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах, цахим үйлчилгээний харилцангалыг дээшлүүлэх**

<p>4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хургах тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	<p>2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх</p>	<p>Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан "Нэг цэгийг" үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагааны хөрөнгө оруулагчийн оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг Хөрөнгө оруулагтын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад дүрэм, журмыг баримтлан <a href="http://www.e-invest.mn">www.e-invest.mn</a> системээр цахимаар хүлээн авч, олгож эхэлсэн. Уг зөвшөөрлийн хүсэлтийг өмнө нь цаасаар ажлын 3 хоногт гардаг байсан бол систем ашиглалтад орсноор ажлын 8 цагт цахимаар олгож байна. "Нэг цэгийг" үйлчилгээний төв"-д төрийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлж, үйлчилгээний шийдвэрлэх хугацааг багасгах, хөрөнгө оруулагчдад тулгардаг хүндрэлийг арилгах, илүү таатай нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Дэлхийн Банк гурлттай хамтран Цахим нэг цонхны системийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд e-invest системийг ашиглалтад оруулснаар гадаадын хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг цахимаар олгож эхэлсэн.</p>
<p>4.1.2.2. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх</p>	<p>2. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх</p>	<p>"Хөрөнгө оруулагтын тухай хууль"-д заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох, хөрөнгө оруулагтын гэрээ байгуулах зэрэг зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.2, 3.2.2.2, Хөрөнгө оруулагтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.1-д тус тус заасны дагуу хөрөнгө оруулагтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох тул уг зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжгүй.</p>
<p>4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт</p>	<p>3. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх</p>	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь санхүүгийн аудит, нийцлийн аудит, дотоод хяналт шалгалтыг төлөвлөхдөө эрсдэлийн үнэлгээнд суурилсан давтамжийн хуваарийг гаргадаг. Санхүүгийн аудит 2022 онд хийгдээгүй бөгөөд шилэн дансны</p>

100.0

100.0

100.0

	Шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох		Мэдээллийн явцад урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хяналт тавьж ажилласан.	
10	4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх 2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх	Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдаж, хуульд зааснаар Эдийн засаг, хөгжлийн яам нь 2022 онд байгуулагдсан тул төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх хугацаа болгоогүй байна.	Хэрэгжилтийг тооцох хугацаа болгоогүй.
11			Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан "Нэг цэгийн үйлчилгээний төв" нь хөрөнгө оруулагчийн оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг Хөрөнгө оруулагтын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад дүрэм, журмыг баримтлан www.e-invest.mn системээр цахимаар хүлээн авч шийдвэрлэдэг. Тайлант хугацаанд уг үйлчилгээг авсан иргэдээс 11-11 төвд санал, гомдол ирүүлээгүй байна.	100.0
<b>Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх</b>				
12	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл" гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах 2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх	Тус яамны харьяа Засгийн газрын тусгай сан байхгүй болно.	100.0
13			Тус яамны харьяа Засгийн газрын тусгай сан байхгүй болно.	100.0
14	4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах	Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарахгүй болно.	Яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай.
15		2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн	Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарахгүй болно.	Яамны чиг үүрэгт

		<p>талаар Засгийн газрын <a href="http://www.iltod.mn">www.iltod.mn</a>, <a href="http://www.shlendans.com">www.shlendans.com</a> цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх</p>		Хамаарахгүй тул хасуулах саналтай.
16	<p>4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, харилцлагын тогтолцоог сайжруулах</p>	<p>2. Иргэн, хуулийн этгээдэд үчруулсан хохирлыг барагдуулсны улмаас захираганы байгууллагад үчирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д зааснаар аудитын дүгнэлт гарсны дараа дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.</p>	Хэрэгжилтийг тооцох хугацаа болгоогүй.
<p><b>Дөрөв. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашгтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, харилцлагыг дээшлүүлэх</b></p>				
17	<p>4.1.4.4. Концесс, шууд гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгох</p>	<p>2. Концессын гэрээ байгуулах аргачлал, шалгуурыг тодорхой болгосон журам боловсруулах</p>	<p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр УИХ-аар эцэслэн батлагдсан. Тус хуульд "Түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичиг"-ийг боловсруулахаар тусгагдсан бөгөөд уг журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, 2023 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.</p>	30.0
18		<p>3. Концесс олгох уралдаант шалгаруулалт болон санал үнэлэх журмыг шударга, өрсөлдөөнтэй, үр дүнтэй, ил тод болгох талаарх зохицуулалтыг шинэчлэн боловсруулах</p>	<p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр УИХ-аар эцэслэн батлагдсан. Тус хуульд "Түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичиг"-ийг боловсруулахаар тусгагдсан бөгөөд уг журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, 2023 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.</p>	30.0
<p><b>Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх</b></p>				
19	<p>4.1.6.2. Хувийн хэвшлийн байгууллагуудыг чадавхжуулж, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн заагийг тодорхойлох</p>	<p>2. Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх асуудлыг судалж, шилжүүлж болгох үйлчилгээний жагсаалт гарган хэрэгжүүлэх</p>	<p>Эдийн засаг, хөгжлийн яаманд "Төрөөс олгодог зарим зөвшөөрөл, бүртгэл, эрх олгох үйл ажиллагааг хувийн хэвшилд шилжүүлэх"-тэй холбоотой ажил үйлчилгээ байхгүй болно.</p>	100.0
20	<p>4.1.6.3. Төр, хувийн хэвшлийн болон хувийн хэвшил хоорондын авлигаас сэргийлэх ажиллагааг өргөжүүлж,</p>	<p>1. Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх үйлзлалтыг бизнесийн чиглэл, салбар бүрээр зохион явуулж, бизнес эрхлэхэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хуралсүхийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Ялон Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр "Монгол-Японы төр, хувийн хэвшлийн 10 дугаар зөвлөлдөх уулзалт" зохион байгуулагдсан. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль" 2022 оны 12 дугаар сарын 09-нд батлагдсанаар төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх эрх зүйн таатай орчин бүрдсэн.</p>	100.0

21	аливаа санаал, санаачилгыг дэмжиж, хамтран	2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах	"Төр, хувийн хэвшлийн туншлэлийн тухай хууль"-ийн 27 дугаар зүйлд "Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан нь ял шийтгэлгүй, төрийн туншлагч этгээдийн удирдах албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, эсхүл хамаарал бүхий этгээд биш, ашиг сонирхлын зөрчилгүй байх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд тухайн этгээдийг туншлалд оролцуулахгүй." гэж заасан бөгөөд тус хуульд заасан "Туншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар"-т авлигаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгахаар төлөвлөж байна.	Дамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай байна.	Дамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай.	100.0
22	4.1.6.4. Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах	4. Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх				
<b>Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих</b>						
23	4.1.7.3. Байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт ажиглагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх	1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх 2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх	Тус яаманд төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ажил, үйлчилгээ байхгүй болно.			100.0
24	Байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашгтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх	3. Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийж, дүнг олон нийтэд мэдээлэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах	"Хөрөнгө оруулалтын тухай хууль"-д заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ олгох, гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд олгох зөвшөөрөл, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах зэрэг зөвшөөрлийг олгох үйл ажиллагаа нь "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ийн 3 дугаар зүйлийн 3.2.2, 3.2.2.2. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 22 дугаар зүйлийн 22.1-д тус тус заасны дагуу хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох тул уг зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжгүй.			100.0
25			Тус яаманд төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ажил, үйлчилгээ байхгүй болно.			100.0
<b>Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх</b>						
26	4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үэлийг төлөвшүүлэхэд иргэн,	4. Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 2022 оны эхний хагас жилийн тайланг 2022 оны 07 сарын 15-ны өдөр, жилийн эцсийн тайланг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Авлигатай тэмцэх газарт тайлагнаж, цахим системд баталгаажуулж акциллгасан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх			100.0

<p>Төрийн болон төрийн бус байгууллагын оролцоор хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх</p>		<p>"Авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2022 оны 03 дугаар сарын 1-ний өдөр болговсруулан төрийн нарийн бичгийн байгуулсан авлигын эсрэг мэдээллийн самбар, цахим хуудсанд даа байршуулсан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх авлигын эсрэг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд албан хаагчдыг сургалтад хамруулах судалгаа, саналыг Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлсэн. 2022 оны 6 сарын 17-ны өдөр Үндэсний хөтөлбөрийн 2022 оны эхний хагас жилийн тайланг цахим системд тайлагнаж, төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулагд хийлгэсэн. 2022 оны байгууллагын шударга байдлын үнэлгээг хийж буй Sisa судалгааны байгууллагатай хамтран ажиллаж судалгаа авахад дэмжлэг үзүүлэн ажилласан.</p> <p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, төлө зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудаст байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, Хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарт сар бүр мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.3, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг хуульд заасан хугацаанд тайланг байгууллагын албан ёсны цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтэд ил тод болгосон. Эдийн засаг, хөгжлийн яамны <a href="http://med.gov.mn/">http://med.gov.mn/</a> цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагаа хэсэгт авлигын эсрэг мэдээ, мэдээлэл <a href="http://med.gov.mn/infoformat-38405">http://med.gov.mn/infoformat-38405</a>, соён гэгээрүүлэх сурталчилгаа шторк <a href="http://med.gov.mn/enlightenment">http://med.gov.mn/enlightenment</a> оруулж авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг дэмжин, сурталчлан ажилласан.</p>
<p>4.1.10.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>1. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх</p>	<p>Авлигатай тэмцэх газраас 2022 онд зохион байгуулах сургагч багш бэлтгэх сургалтад Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтнийг хамруулсан.</p>

\*\*\*ООО\*\*\*

100.0